



ХЭНТИЙ АЙМГИЙН ДАДАЛ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 416

Баян-Овоо

Данс бүртгэлээс хасаж актлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 04 дүгээр тогтоолын хавсралт “Орон нутгийн өмчид хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”, 2022 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 5.11 дэх заалт, аймгийн ИТХ-ын 2025 оны 13 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны А/224 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Орон Нутгийн Өмчийн Газрын 2025 оны 10 сарын 24-ний 389 дүгээр албан бичиг ирүүлсэн зөвшөөрлийн дагуу машин тоног төхөөрөмж болон тавилга эд хогшлын дансанд үлдэх өртөггүй, элэгдлийн хугацаа дууссан 14 нэр төрлийн 17 ширхэг 8517,280 (Найман сая таван зуун арван долоон мянга хоёр зуун наян мянган) төгрөгний хөрөнгийг данснаас хасаж, актлахыг нягтлан бодогч (Э. Өлзийсайхан), нярав (Б. Ундармаа) нарт үүрэг болгосугай.

2. Үндсэн хөрөнгийн бүртгэлд хяналт тавьж, холбогдох тайлан мэдээг танилцуулахыг байгууллагын “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн дарга (О. Насанжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Ш. ГАНГАНТУУЛ